



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.24 № 03/8806

танай _____ -ны № _____ -т

Гомдол хянасан тухай

“МОНГОЛЫН ИРГЭНИЙ
АГААРЫН ТЭЭВЭР” ТӨХК-Д

*Ч.Б. Ганзориг
Ч.Б. Ганзориг
Холбогдох худалдч №8-р
зүйлийн дагуу дахин
чухалх*

Д.А.Г. 8/30

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240103122 дугаартай “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Ард даатгал” ХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Ард даатгал” ХК-ийн гомдолд тус компанийн тендерт ирүүлсэн гурван гэрээнээс ижил төстэй гэрээ болох “Томас эйр” ХХК-тай байгуулсан гэрээний хуулбар болон гэрээ дүгнэсэн акт ирүүлээгүй, олон улсын даатгалын зах зээл дээр Даатгуулагчийн агаарын хөлгийн даатгалыг тэргүүлэх Тэргүүлэгч буюу Үндсэн давхар даатгагчаар ажиллах компанийн баталгаа бүхий албан захидал, орчуулгын хамт ирүүлэх ба Тэргүүлэгч нь албан захидалдаа (а) даатгалын нийт эрсдэлийн 10 хувиас багагүй хувийн эрсдэлийг авахаа баталгаажуулсан байх, (б) ижил төстэй болон дэлхийн томоохон агаарын тээврийн компанийн агаарын хөлгийн даатгал/давхар даатгалыг тэргүүлж байсан туршлагын талаар мэдээллийг ирүүлээгүй, ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор Даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах даатгалд хамруулсан байх шаардлага хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй, мөн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Бодьдаатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн зээлийн санхүүжилт хийх боломжтой тодорхойлолт шаардлага хангахгүй, хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг нууцлалтай ирүүлсэн нь тендер шалгаруулалтын баримт бичгийн холбогдох шаардлага хангахгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

I. Гомдолд дурдсан үндэслэлээр “Ард даатгал” ХК-ийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.4-т “Ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор Даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг хариуцах даатгалын хувьд “0” байх.” гэж заасан байна.

9766016639

| |
|---|
| УЛААНБААТАР ХОТ |
| МИАТ ТӨХК |
| ТТМ № 2287 |
| Бүртгэсэн №... карт № 1388 |
| Он, сар, өдөр. 2024.10.30 нь авчарч отөв. |
| цаг минут |
| дэшилжүүлэв. |
| Хуудасны тоо |

Бүртгэсэн №... карт № 1388
Он, сар, өдөр. 2024.10.30 нь авчарч отөв.

..... цаг минут

..... дэшилжүүлэв.

Хуудасны тоо

“Ард даатгал” ХК-ийн тендерт ирүүлсэн “Галлагер” компанийн захидалд “... Ангарын болон газрын үйлчилгээний хариуцлагын үүний дотор Даатгуулагч гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн агаарын хөлөгт үзүүлж буй газрын болон засвар үйлчилгээнээс гуравдагч этгээдэд учирч болзошгүй хохирлыг бид даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагагүйгээр даатгалын хамгаалалтад багтааж байгаа болно.” гэж дурдсан, мөн давхар даатгалын B0746GA2306948000 дугаартай гэрээний 2 дугаар бүлэгт “Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага”-тай холбоотой заалтууд тусгагдсан байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.4-т заасан мэдээлэл ирүүлээгүй гэж хянан үзсэн нь үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”. Сүүлийн 3 жилийн аль 1 жилд ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагын мэдээлэл гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлэх. Сүүлийн 3 жилд МИАТ ТӨХК-тай даатгалын /агаарын хөлгийн болон бусад төрлийн даатгал/ үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байсан бол гэрээний биелэлтийг дүгнэсэн гэрээ дүгнэсэн акт, хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний хувьд явцын гэрээ дүгнэсэн акт ирүүлнэ.” гэж заасан байна.

“Ард даатгал” ХК тендert Иргэний нисэхийн ерөнхий газартай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үргэлжилсэн “Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал”-ын үйлчилгээний гэрээ, тус газартай байгуулсан 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл үргэлжилсэн “Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэх буудлуудын талбайд гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал”-ын үйлчилгээний гэрээ, “Томас эйр” ХХК-тай байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилсэн “Агаарын хөлгийн даатгал, хариуцлагын даатгал, нисэх бүрэлдэхүүний гэнэтийн ослын даатгал, газрын эрсдэлийн даатгал”-ын үйлчилгээ гэрээ, “Тийс монгол” ХХК-тай байгуулсан 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилсэн “Хөрөнгийн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх гэрээний мэдээлэл тус тус ирүүлсэн байна.

“Ард даатгал” ХК тендert “Томас эйр” ХХК-тай байгуулсан 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилсэн “Агаарын хөлгийн даатгал, хариуцлагын даатгал, нисэх бүрэлдэхүүний гэнэтийн ослын даатгал, газрын эрсдэлийн даатгал”-ын гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актыг ирүүлээгүй байх бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газартай байгуулсан “Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал” болон “Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэх буудлуудын талбайд гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан шаардлагад ижил төстэй үйлчилгээнд хамаарах эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.2-т “Давхар даатгалын хувьд: Олон улсын даатгалын зах зээл дээр Даатгуулагчийн агаарын хөлгийн даатгалыг тэргүүлэх Тэргүүлэгч буюу Үндсэн давхар даатгагчаар ажиллах компанийн баталгаа бүхий албан захидал, орчуулгын хамт ирүүлнэ. Тэргүүлэгч нь албан захидалдаа: (а) даатгалын нийт эрсдэлийн 10%-аас багагүй

хувийн эрсдэлийг захиалан авахаа баталгаажуулсан байх; (б) ижил төстэй болон дэлхийн томоохон агаарын тээврийн компанийн агаарын хөлгийн даатгал/давхар даатгалыг тэргүүлж байсан туршлагын талаар мэдээллийг ирүүлнэ.” гэж заасан байна.

“Ард даатгал” ХК тэндерт “AJG” компанийн албан мэдэгдэл, туршлагын талаарх мэдээлэл ирүүлсэн байх ба мэдэгдэлд “Upon appointment we will place 100% of MIAT’s Aviation Insurance programme with the above “A” rated Insurers in London and markets across the world by 15th, November 2024.” (“Томилогдсон даруйд бид 2024 оны 11 сарын 15 гэхэд Лондон болон дэлхийн бусад зах зээл дэх дээр дурдсан “A” үнэлгээтэй давхар даатгалын компаниудад “MIAT” компанийн агаарын хөлгүүдийг давхар даатгалд 100% байршуулах болно.”) гэж дурдсан байгаа нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1.2-ын (а)-д заасан шаардлагад нийцэх эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.

II. Гомдолд дурдсан үндэслэлээр захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Бодъдаатгал” ХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ буюу түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 90 хувиас багагүй байх. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн нийт дунг дараах 3 шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд: 1. Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/ 2. Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. 3. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд” гэж, ТШЗ 2.1-д “Нийт төсөвт өртөг: 12,411,191,510 /Арван хоёр тэрбум дөрвөн зуун арван нэгэн сая нэг зуун ерэн нэгэн мянга таван зуун арав/” гэж тус тус заасан байна.

“Бодъдаатгал” ХК тэндерт ААН банкны Спортын төв ордон тооцооны төвийн 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 5031/24/289 тоот “... ХААН банкны Зээлийн бодлого, бүтээгдэхүүний журмын дагуу холбогдох шаардлагыг хангасан нөхцөлд 26,000,000,000.0 (хорин зургаа тэрбум) төгрөгийн зээлийн санхүүжилт хийх боломжтой” тухай тодорхойлолт ирүүлсэн байна.

Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 6.2-т “Харилцагч банкны мэдэгдэл нь зээл олгох асуудлыг судлан үзэх боломжтой гэх мэт банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй бол түүнийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.” гэж заасанд “Бодъдаатгал” ХК-ийн тэндерт ирүүлсэн ХААН банкны Спортын төв ордон тооцооны төвийн дээрх тодорхойлолтыг нийцсэн гэж хянан үзсэн нь үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 25.5-д “Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Оролцогч нь Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.” гэж, мөн тендер шалгаруулалтын зааварчилгааны 25.4-т “Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан

мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.” гэж, хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3 дахь заалтад “энэ хуулийн 22.5-д заасан үндэслэлээр ил болгохгүй баримт бичиг, мэдээлэл байгаа бол түүний хууль зүйн үндэслэлийг тайлбарласан мэдэгдлийг ил болгохыг зөвшөөрч илгээнэ.” гэж заасан байна.

“Бодьдаатгал” ХК тендерт 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/844 тоот “... ТШЗ 19.1 болон ТШЗ 19.2-т заасны дагуу харилцагч байгууллагын ижил төстэй гэрээнүүдийг хавсаргасан ба “Бодьдаатгал” ХК-ийн байгууллагын дотоод журам болон холбогдох даатгалын гэрээгээр “даатгалын гэрээтэй холбоотой мэдээллийг нууцална.” гэсэн үүрэг хүлээсний дагуу мэдээллийг нууцлах хүсэлтэй байна.” гэж дурдсан мэдээллийг нууцлах тухай албан бичгийг ил болгож ирүүлээгүй байх тул дээрх шаардлага хангасан гэж хянан үзсэн нь үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/2503 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Ард даатгал” ХК-д.

